

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



## **САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: ДГА-2019/13/СТА-ТТЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд хот

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: [Dornogovi@audit.gov.mn](mailto:Dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: [Lundegmaa.Ts@audit.gov.mn](mailto:Lundegmaa.Ts@audit.gov.mn)

Аудитор:

О.Нарангарав

Утас: 70523020

Цахим хаяг: [Narangarav.O@audit.gov.mn](mailto:Narangarav.O@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |

## Агуулга

---

|         |   |    |
|---------|---|----|
| 1       | Аудитын гэрчилгээ .....   | 3  |
| 2       | Аудитын тайлан .....  | 5  |
| 2.1.    | Оршил .....   | 5  |
| 2.2.    | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....   | 5  |
| 2.3.    | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....  | 6  |
| 2.4.    | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....   | 6  |
| 2.5.    | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 8  |
| 2.6.    | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....  | 8  |
| 2.7.    | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....   | 8  |
| 2.8.    | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....  | 9  |
| 2.8.1   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....     | 9  |
| 2.8.2   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....               | 10 |
| 2.8.2.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....                                    | 11 |
|         | Шийдвэрлэсэн: Аудитын явцад татварын нэр төрлөөр орлогын дансанд залруулан бүртгэсэн. ....                    | 11 |
| 2.9.    | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | 11 |
| 2.10.   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....   | 12 |
| 2.11.   | Шилэн дансны мэдээлэл .....   | 13 |
| 2.12.   | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....  | 13 |
| 2.13.   | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....  | 13 |
| 2.14    | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....   | 14 |
| 3.      | Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....  | 15 |
| 3.1     | Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН .....  | 15 |
| 3.2     | Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН .....   | 17 |
| 3.3     | Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....  | 20 |
| 3.4     | Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН .....  | 23 |
| 3.5     | Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....  | 24 |

---

## 1 Аудитын гэрчилгээ

|   |  |
|---|--|
| <br><b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ<br/>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b><br>44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,<br>3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,<br>Утас: (705) 2-27-34   | <b>ДОРНОГОВЬ АЙМГИЙН<br/>УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ<br/>ДАРГА Ц.ЭРХЭМБОЛД ТАНАА</b> |
| <u>2019.03.25</u> № <u>1-6/344</u>  |  |
| танай _____ -ны № _____ -т  |  |
| <b>Аудитын гэрчилгээ</b>  |  |
| <p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улаанбадрах сумын Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>   |  |
| <b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>  |  |
| <p>Улаанбадрах сумын Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>              |  |
| <b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>  |  |
| <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p> |  |
| <p>Аудитаар Улаанбадрах сумын Төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>        |  |
| <p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>  |  |

### Үүрэг, хариуцлага

Улаанбадрах сумын Төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Ц.Эрхэмболд-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.18-наас 2019.03.20.-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.21.-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.04-ны өдрийн 1/62 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улаанбадрах сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Улаанбадрах сумын Засаг дарга нь “Засгийн газраас эрх нь шилжиж ирсэн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, сум, байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсөв болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төсвийн захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино” гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээнд Өргөн сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Нийтийн албаны бодлого
2. Хяналт шинжилгээ, мэдээлэл боловсруулалт
3. Хууль зүйн салбарын нийлүүлэх ажил үйлчилгээ
4. Батлан хамгаалах ажил үйлчилгээ
5. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээ
6. Санхүү, төрийн сангийн ажил үйлчилгээ
7. Худалдан авах ажиллагаа
8. Нийгмийн салбарын ажил үйлчилгээ
9. Үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, газрын харилцаа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлийн ажил үйлчилгээ

Улаанбадрах сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд
- Сангийн сайд болон бусад сайдын тушаал шийдвэрүүд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 10 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 6 байгууллага, 4 сан аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Улаанбадрах сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| №          | Байгууллагын ангилал         | Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр |             |                |                     |                      |
|------------|------------------------------|---|-------------|----------------|---------------------|----------------------|
|            |                              | Санал дүгнэлт гаргасан                    | Түүвэрлэсэн | Итгэл үзүүлсэн | Гэрээгээр хийлгэсэн | Аудитад хамрагдаагүй |
| 1          | Төсвийн шууд захирагч        | 4   | 2           | -              | -                   | -                    |
| 2          | Төсвийн төвлөрүүлэн захирагч | 1   | 3           | -              | -                   | -                    |
| <b>Дүн</b> |                              | <b>5</b>                                  | <b>5</b>    | -              | -                   | -                    |

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улаанбадрах сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбадрах сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд шаардлаггүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улаанбадрах сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Улаанбадрах сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт орлого, зарлагын дүнгээс их байгаатай холбоотой юм.

Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны цэвэр хөрөнгө 4,155.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 83.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь гүйцэтгэлийн явцад нэгтгэл тайланд хамрагдах байгууллагуудын алдаа зөрчлийн тархалтын байдлыг тодорхойлохтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Улаанбадрах сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 60,798.8 мянган, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 12,580.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 14,066.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

### **2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар**

#### **Асуудал 1: Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

Улаанбадрах сумын ЕБС тайлант хугацаанд түлш нүүрс, хоол хүнс, эд хогшил, урсгал засварын зардалд нийт 42,908.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан. ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчин ХАА-ны төлөвлөгөө хийгээгүй, худалдан авах ажил үйлчилгээг нийтэд зарлаагүй, харьцуулалтын арга хэрэглэж гүйцэтгэгчийг сонгоогүй, шууд худалдан авалт хийж ХАА-ны хууль зөрчсөн байна.

#### **Шийдэл:**

Алдаа зөрчилд албан шаардлага өгсөн.

#### **Асуудал 2: Төсвийн өмнө хүлээсэн биелэлт**

Улаанбадрах сумын төсөвт байгууллагууд санхүүгийн тайланг хугацаа хоцроож аудитын байгууллагуудад ирүүлж төсвийн тухай хууль зөрчсөн байна.

**Шийдэл:**

Зөвлөмж өгсөн болно.

**Асуудал 3: Анхан шатны баримт бүрдэлттэй холбоотой**

Улаанбадрах сумын ЕБС тайлант онд үндсэн хөрөнгө 16,201.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, оны эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан зардлыг тусгаагүй, зардлыг бодит гүйцэтгэлээр нь бус төсвийн хуваарийн дагуу бичилт хийж тодруулга тайланг зөрүүтэй тайлагнасан байна.

**Шийдэл:**

Аудитаар зөвлөмж өгсөн.

**2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

**Үүнээс: Залруулгын ангилал**

| № | Залруулгын товч утга | Мөнгөн дүн (мянган төгрөгөөр) | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой | Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа | Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа | Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой |
|---|----------------------|-------------------------------|---|--|--|---|
|---|----------------------|-------------------------------|---|--|--|---|

**Дүн**

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| №          | Шийдэл  | Тоо      | Дүн         | (Мянган төгрөгөөр) |
|------------|---|----------|-------------|--------------------|
|            |   |          |             | Тайлбар            |
| 1          | Зөвлөмж өгсөн                                   | 0        | 0.00        |                    |
| 2          | Төлбөрийн акт тогтоосон                         | 0        | 0.00        |                    |
| 3          | Албан шаардлага өгсөн                           | 0        | 0.00        |                    |
| 4          | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн        | 0        | 0.00        |                    |
| 5          | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0        | 0.00        |                    |
| <b>Дүн</b> |   | <b>0</b> | <b>0.00</b> |                    |

**2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд: Байхгүй

**2.8.2.1.1 Балансын данстай холбоотой асуудал**

Татварын орлого болох ҮҮХ борлуулсны орлого 380.0 мянган төгрөг болон хадгаламжийн хүүгийн орлого 12,004.3 мянган төгрөгийг бусад орлогын албан татварт нийлүүлж бүртгэсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:**

Шийдвэрлэсэн: Аудитын явцад татварын нэр төрлөөр орлогын дансанд залруулан бүртгэсэн.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Нөхөн сэргээлтийн сан дансанд байршуулсан хөрөнгийг тайлант хугацааны үр дүн гэж тайлагнан, хандивласан барьцаа хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Иймд дараагийн аудитаар хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниас үйл ажиллагаа явуулсан тухайн жилийн эцэст байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор барьцаанд байршуулсан хөрөнгийг өр төлбөрөөр бүртгэж, хандивласан барьцаа хөрөнгийг ЗДТГ-ын нэмэлт дансанд орлого хүлээн зөвшөөрч тайлагнах асуудлыг авч үзэх нь зүйтэй.

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улаанбадрах сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1,320.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1,547.1 сая төгрөг буюу 105.8 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1,236.8 сая төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь татварын орлого 2.2 сая төгрөгөөр давж, төсөвт байгууллагуудын зардал 21.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь шалтгаалжээ.

Сумын татварын орлогыг 38,540.0 мянган төгрөгөөр татварын бус орлогыг 5,000.0 мянган төгрөгөөр нийт орлогыг 43,540.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 806,096.5 мянган төгрөг, ОНХСангийн санхүүжилт 74,886.8 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс авах татаас санхүүжилт 244,537.8 мянган төгрөгөөр нийт төсвийн орлогыг 1,094,174.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын төсвийг 46,411.2 мянган төгрөг, ЗДТГазар 241,666.6 мянган төгрөг, ОНХСан 74,886.8 мянган төгрөг, тусгай шилжүүлгийн байгууллагын шилжүүлэг 806,096.5 мянган төгрөг буюу нийт төсвийн зарлагыг 1,094,174.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Нөхөн сэргээлтийн сангийн орлого зарлагыг 30,396.8 мянган төгрөгөөр, Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг 121,000.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл:

|   |                                | Төлөвлөгөө<br>/ мян.төг/ | Гүйцэтгэл<br>/мян.төг/ | Зөрүү<br>/дутуу +,<br>илүү - / | Хувь         |
|---|--------------------------------|--------------------------|------------------------|--------------------------------|--------------|
| 1 | <b>ХХОАТ</b>                   | <b>15,760.00</b>         | <b>16,478.21</b>       | <b>(718.21)</b>                | <b>104.6</b> |
|   | Үйл ажиллагааны орлогын татвар | 3,360.00                 | 3,548.91               | (188.91)                       | 105.6        |
|   | Бусад орлогын татвар           | 12,400.00                | 12,929.29              | (529.29)                       | 104.3        |
| 2 | Бууны татвар                   | 2,310.00                 | 2,630.00               | (320.00)                       | 113.9        |
| 3 | УТХураамж                      | 1,000.00                 | 1,236.33               | (236.33)                       | 123.6        |
| 4 | Хог хаягдлын хураамж           | 7,770.00                 | 7,891.00               | (121.00)                       | 101.6        |
| 5 | ТТАМАТөлбөр                    | 100.00                   | 100.00                 | -                              | 100.0        |
| 6 | Хадгаламж хүү                  | 11,600.00                | 12,004.33              | (404.33)                       | 103.5        |

|   |   |                  |                  |                   |              |
|---|---|------------------|------------------|-------------------|--------------|
| 7 | ҮХХ борлуулсны орлого                             | -                | 380.00           | (380.00)          | 100.0        |
| 8 | Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого | 5,000.00         | 5,332.25         | (332.25)          | 106.6        |
|   | <b>Дүн</b>  | <b>43,540.00</b> | <b>46,052.11</b> | <b>(2,512.11)</b> | <b>105.8</b> |

Сумын ИТХ болон ЗДТГ-ын төсвийн гүйцэтгэл 284,619.7 мянган төгрөг буюу 96.4 хувьтай, тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 790,265.6 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байна.

Аймгаас 244,537.8 мянган төгрөгийн татаас санхүүжилт авч, татварын давсан орлого 2,179.9 мянган төгрөгийг, сумын ЗДТГ, ИТХ зарцуулаагүй үлдэгдэл 3,790.3 мянган төгрөгийг аймгийн төсөвт, тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн хэмнэлт 15,833.9 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус татан төвлөрүүлсэн байна.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Улаанбадрах сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Улаанбадрах сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 19.2 хувь буюу 14,066.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 58.5 хувь буюу 42,908.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 22.4 хувь буюу 16,404.6 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлжээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

| №   | Байгууллагын ангилал | (мянган төгрөг) |                 |          |                 |           |                 |          |                 |
|-----|----------------------|-----------------|-----------------|----------|-----------------|-----------|-----------------|----------|-----------------|
|     |                      | Илрүүлэлт       |                 |          |                 | Залруулга |                 |          |                 |
|     |                      | Зөрчил          |                 | Алдаа    |                 | Бүгд дүн  |                 |          |                 |
| Тоо | Дүн                  | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн             | Тоо       | Дүн             |          |                 |
| 1   | ТТЗ                  | 0               | 0.0             | 2        | 12,580.3        | 2         | 12,580.3        | 2        | 12,580.3        |
| 2   | ТШЗ                  | 6               | 59,312.8        | 2        | 1,486.0         | 8         | 60,798.8        | 2        | 1,486.0         |
|     | <b>Дүн</b>           | <b>6</b>        | <b>59,312.8</b> | <b>4</b> | <b>14,066.3</b> | <b>10</b> | <b>73,379.1</b> | <b>4</b> | <b>14,066.3</b> |

## Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(мянган төгрөг)

| № | Байгууллагын ангилал | Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт |                 |               |          |                 |                 |          |                 |                            |          |  |          |
|---|----------------------|--|-----------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|-----------------|----------------------------|----------|--|----------|
|   |                      | Залруулаагүй алдаа, зөрчил                       |                 | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |                 | Хариуцлага тооцуулах санал |          | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|   |                      | Тоо  | Дүн             | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн             | Тоо                        | Дүн      | Тоо  | Дүн      |
| 1 | ТТЗ                  | 0  | -               | 0             | -        | 0               | -               | 0        | -               | 0                          | -        | 0  | -        |
| 2 | ТШЗ                  | 6  | 59,312.8        | 0             | 0.0      | 1               | 42,908.2        | 5        | 16,404.6        | 0                          | -        | 0  | -        |
|   | <b>Дүн</b>           | <b>6</b>   | <b>59,312.8</b> | <b>0</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>42,908.2</b> | <b>5</b> | <b>16,404.6</b> | <b>0</b>                   | <b>-</b> | <b>0</b>                                       | <b>-</b> |

### 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

| № | Байгууллагын ангилал | Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор) |                |          |                                  |          |
|---|----------------------|-----------------------------------|----------------|----------|----------------------------------|----------|
|   |                      | Зөрчилгүй                         | Хязгаарлалттай | Сөрөг    | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | Дүн      |
| 1 | ТШЗ                  | 3                                 | 1              | 0        | 0                                | 4        |
| 2 | ТТЗ                  | 1                                 | 0              | 0        | 0                                | 1        |
|   | <b>Дүн</b>           | <b>4</b>                          | <b>1</b>       | <b>0</b> | <b>0</b>                         | <b>5</b> |

### 3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

#### 3.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Код          | Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|--------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>     | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                    | <b>455,831,955.14</b>   | <b>474,491,416.93</b>   |
| <b>31</b>    | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                             | <b>76,422,568.27</b>    | <b>81,790,938.12</b>    |
| <b>31200</b> | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                 | <b>76,422,568.27</b>    | <b>81,790,938.12</b>    |
| <b>31210</b> | <b>Төгрөг</b>                                     | <b>76,422,568.27</b>    | <b>81,790,938.12</b>    |
| 31211        | Төрийн сангийн харилцах                           | 76,401,810.12           | 81,790,938.12           |
| 31216        | Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк               | 20,758.15               | -                       |
| <b>33</b>    | <b>АВЛАГА</b>                                     | <b>154,627,553.50</b>   | <b>154,868,439.50</b>   |
| 33100        | Ажиллагчидтай холбогдсон авлага                   | 1,861,800.00            | 418,973.00              |
| <b>33500</b> | <b>Бусад авлага</b>                               | <b>1,428,350.00</b>     | <b>529,714.00</b>       |
| 33510        | Байгууллагаас авах авлага                         | 301,950.00              | 357,594.00              |
| 33520        | Хувь хүмүүсээс авах авлага                        | 1,126,400.00            | 172,120.00              |
| <b>33600</b> | <b>Зээлийн авлага</b>                             | <b>151,337,403.50</b>   | <b>153,919,752.50</b>   |
| <b>33610</b> | <b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b> | <b>151,337,403.50</b>   | <b>153,919,752.50</b>   |
| 33612        | Хувь хүмүүст олгосон зээл                         | 151,337,403.50          | 153,919,752.50          |
| <b>35</b>    | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                             | <b>224,781,833.37</b>   | <b>237,832,039.31</b>   |
| <b>35100</b> | <b>Түүхий эд материал</b>                         | <b>55,139,907.73</b>    | <b>61,795,397.21</b>    |
| 35110        | Тусгай зориулалттай материал                      | 54,545,917.93           | 61,288,297.72           |
| 35130        | Эм боох материал                                  | 593,989.80              | 507,099.49              |
| <b>35400</b> | <b>Хангамжийн материал</b>                        | <b>167,356,725.64</b>   | <b>173,751,442.10</b>   |
| 35410        | Бичиг хэргийн материал                            | 4,678,540.00            | 5,277,869.00            |
| 35420        | Аж ахуйн материал                                 | 33,246,569.10           | 40,715,166.25           |
| 35440        | Түлш, шатах тослох материал                       | 28,655,436.00           | 26,730,457.22           |
| 35450        | Барилгын засварын материал                        | 54,400.00               | -                       |
| 35460        | Хүнсний материал                                  | 6,036,532.00            | 8,359,856.80            |
| 35470        | Бусад хангамжийн материал                         | 94,685,248.54           | 92,668,092.83           |
| 35600        | Мал амьтад  | 2,285,200.00            | 2,285,200.00            |
| <b>2</b>     | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                | <b>3,151,894,668.67</b> | <b>3,683,690,455.62</b> |
| <b>39</b>    | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                             | <b>3,151,894,668.67</b> | <b>3,683,690,455.62</b> |
| <b>39200</b> | <b>Биет хөрөнгө</b>                               | <b>3,151,416,335.38</b> | <b>3,583,214,455.62</b> |
| 39201        | Барилга, байгууламж, орон сууц                    | 3,063,952,067.00        | 2,564,836,972.00        |
| 39202        | Хуримтлагдсан элэгдэл                             | (793,683,528.85)        | (4,715,312.43)          |
| 39203        | Авто-тээврийн хэрэгсэл                            | 255,431,001.00          | 282,015,290.00          |
| 39204        | Хуримтлагдсан элэгдэл                             | (155,434,517.30)        | (184,723,040.60)        |
| 39205        | Машин тоног төхөөрөмж(компьютер)                  | 403,627,023.74          | 406,628,341.20          |
| 39206        | Хуримтлагдсан элэгдэл                             | (265,815,697.41)        | (264,611,140.51)        |
| 39207        | Тавилга, аж ахуйн эд хогшил                       | 186,742,205.71          | 184,529,571.70          |
| 39208        | Хуримтлагдсан элэгдэл                             | (126,763,804.35)        | (134,303,994.10)        |
| 39213        | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс                  | 2,541,050.00            | 2,541,050.00            |
| 39214        | Бусад үндсэн хөрөнгө                              | 849,686,028.35          | 948,803,908.67          |
| 39215        | Хуримтлагдсан элэгдэл                             | (287,214,887.20)        | (237,530,135.00)        |
| 39217        | Ном   | 18,349,394.69           | 19,742,944.69           |
| <b>39300</b> | <b>Биет бус хөрөнгө</b>                           | <b>478,333.29</b>       | <b>100,476,000.00</b>   |
| 39301        | Програм хангамж                                   | 3,605,000.00            | 3,605,000.00            |
| 39302        | Хуримтлагдсан элэгдэл                             | (3,126,666.71)          | (3,255,000.00)          |
| 39303        | Бусад биет бус хөрөнгө                            | -                       | 100,126,000.00          |
| <b>3</b>     | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                | <b>3,607,726,623.81</b> | <b>4,158,181,872.55</b> |
| <b>4</b>     | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                             | <b>6,884,565.00</b>     | <b>2,234,617.00</b>     |

Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|              |   |                                |                                |
|--------------|---|--------------------------------|--------------------------------|
| <b>41</b>    | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | <b>6,884,565.00</b>            | <b>2,234,617.00</b>            |
| <b>41300</b> | <b>Өглөг</b>  | <b>6,884,565.00</b>            | <b>2,234,617.00</b>            |
| 41310        | Ажилчидтай холбогдсон өглөг   | 6,113,826.00                   | 1,494,002.00                   |
| <b>41360</b> | <b>Бусад өглөг</b>  | <b>770,739.00</b>              | <b>740,615.00</b>              |
| 41361        | Байгууллагад төлөх өглөг  | 350,509.00                     | 521,665.00                     |
| 41362        | Хувь хүмүүст төлөх өглөг  | 420,230.00                     | 218,950.00                     |
| <b>5</b>     | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>3,600,842,058.81</b>        | <b>4,155,947,255.55</b>        |
| <b>51</b>    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>3,600,842,058.81</b>        | <b>4,155,947,255.55</b>        |
| 51100        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,022,833,186.61               | 2,122,959,186.61               |
| <b>51200</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | <b>937,845,494.06</b>          | <b>408,454,426.25</b>          |
| 51210        | Өмнөх үеийн үр дүн  | 851,257,517.81                 | 939,548,119.99                 |
| 51220        | Тайлант үеийн үр дүн  | 86,587,976.25                  | (531,093,693.74)               |
| 51300        | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 640,163,378.14                 | 1,624,533,642.69               |
| <b>6</b>     | <b><u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</u></b>             | <b><u>3,607,726,623.81</u></b> | <b><u>4,158,181,872.55</u></b> |

### 3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Код           | Үзүүлэлт   | ӨМНӨХ ОН                | ТАЙЛАНТ ОН              |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| <b>I</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>1,947,058,467.06</b> | <b>1,714,278,097.48</b> |
| <b>11</b>     | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>   | <b>43,230,838.51</b>    | <b>28,715,534.18</b>    |
| <b>110</b>    | <b>Орлогын албан татвар</b>  | <b>28,858,918.51</b>    | <b>16,478,206.18</b>    |
| <b>1100</b>   | <b>Хувь хүний орлогын албан татвар</b>   | <b>28,858,918.51</b>    | <b>16,478,206.18</b>    |
| 110002        | Үйл ажиллагааны орлого   | 7,957,069.00            | 3,548,913.00            |
| 110008        | Шууд бус орлого  | 20,901,849.51           | 12,929,293.18           |
| <b>113</b>    | <b>Хөрөнгийн албан татвар</b>  | <b>2,530,000.00</b>     | <b>3,010,000.00</b>     |
| 113001        | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар  | -                       | 380,000.00              |
| 113002        | Бууны албан татвар   | 2,530,000.00            | 2,630,000.00            |
| <b>118</b>    | <b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>   | <b>11,841,920.00</b>    | <b>9,227,328.00</b>     |
| <b>1180</b>   | <b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>   | <b>11,841,920.00</b>    | <b>9,227,328.00</b>     |
| 118001        | Улсын тэмдэгтийн хураамж   | 908,420.00              | 1,236,328.00            |
| 118006        | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр  | 100,000.00              | 100,000.00              |
| 118009        | Хог хаягдлын үйлчилгээний хураамж  | 10,833,500.00           | 7,891,000.00            |
| <b>12</b>     | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>330,907,399.40</b>   | <b>246,910,404.15</b>   |
| <b>120</b>    | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | <b>330,907,399.40</b>   | <b>191,490,404.15</b>   |
| 120002        | Хүүгийн орлого   | -                       | 12,004,327.03           |
| 120003        | Торгуулийн орлого  | 1,500,000.00            | -                       |
| <b>120004</b> | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>  | <b>329,407,399.40</b>   | <b>179,486,077.12</b>   |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 5,435,000.00            | 6,588,500.00            |
| 1200042       | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 7,603,550.00            | 5,332,250.00            |
| 1200045       | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 310,325,690.40          | 160,953,463.12          |
| 1200046       | Зээлийн хүүгийн орлого   | 6,043,159.00            | 6,611,864.00            |
| <b>122</b>    | <b>Тусламжийн орлого</b>   | <b>-</b>                | <b>55,420,000.00</b>    |
| 122001        | Хандив тусламж /дотоод/  | -                       | 55,420,000.00           |
| <b>13</b>     | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>1,572,920,229.15</b> | <b>1,438,652,159.15</b> |
| <b>1310</b>   | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | <b>986,006,400.00</b>   | <b>879,144,800.00</b>   |
| 131007        | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих   | 822,052,000.00          | 804,258,000.00          |
| 131008        | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих  | 163,954,400.00          | 74,886,800.00           |
| <b>1311</b>   | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>20,459,820.15</b>    | <b>31,891,759.15</b>    |
| 131104        | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,786,080.00           | 28,978,501.00           |
| 131105        | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 673,740.15              | 2,913,258.15            |
| <b>1320</b>   | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | <b>566,454,009.00</b>   | <b>527,615,600.00</b>   |
| 132001        | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 302,824,400.00          | 283,077,800.00          |
| 132003        | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/                           | 531,509.00              | -                       |
| 132006        | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/                                      | 263,098,100.00          | 244,537,800.00          |
| <b>II</b>     | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>1,858,261,831.91</b> | <b>1,678,281,439.26</b> |
| <b>21</b>     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1,858,261,831.91</b> | <b>1,606,469,052.26</b> |
| <b>210</b>    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>1,453,352,721.40</b> | <b>1,285,994,818.05</b> |

Улаанбадрах сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | <b>720,505,222.00</b> | <b>741,962,718.00</b> |
| 210101      | Үндсэн цалин   | 640,948,013.00        | 653,970,825.00        |
| 210102      | Нэмэгдэл   | 30,059,819.00         | 40,483,152.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | -                     | 3,294,000.00          |
| 210104      | Урамшуулал   | 17,844,137.00         | 30,216,596.00         |
| 210105      | Гэрээт ажлын хөлс  | 31,653,253.00         | 13,998,145.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>83,732,179.00</b>  | <b>94,376,905.00</b>  |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 55,359,132.00         | 63,616,217.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 6,523,945.00          | 7,966,602.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 6,301,350.00          | 5,891,496.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 1,413,036.00          | 1,838,497.00          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 14,134,716.00         | 15,064,093.00         |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>63,913,863.00</b>  | <b>63,384,483.00</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 10,355,113.00         | 10,791,323.00         |
| 210302      | Түлш, халаалт  | 51,185,550.00         | 48,962,560.00         |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 2,373,200.00          | 3,630,600.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>214,221,994.70</b> | <b>64,737,954.49</b>  |
| 210401      | Бичиг хэрэг  | 6,825,163.00          | 8,292,928.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 24,001,566.42         | 30,832,320.78         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,826,780.00          | 4,732,449.00          |
| 210404      | Ном, хэвлэл  | -                     | 19,200.00             |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 1,056,750.00          | 1,957,850.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 3,653,598.00          | 8,491,789.20          |
